



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

**Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, хөтөлбөр болон орон нутгийн бусад зардлын эх үүсвэрээр хэрэгжих барилга байгууламж, авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт, тохижилт бүтээн байгуулалт, инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, чанар, стандартын шаардлага хангуулах, байнгын ашиглалтад оруулах комиссыг нэгдүгээр, зураг төсөлд хяналт тавих ажлын хэсгийг хоёрдугаар, тоног төхөөрөмж, бараа, материалыг хүлээж авах, байнгын ашиглалтад оруулах ажлын хэсгийг гуравдугаар, гүйцэтгэл баталгаажуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Захиалагчийн хяналтыг гүйцэтгэлийн үе шат бүрт мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс (Л.Отгонбаяр), Хяналт–Шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ч.Мөнхгэрэл), “Хан-Уул Яармаг” ОНӨААТҮГ (Б.Амартүвшин)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захиалагчийн хяналтын зардлыг холбогдох хууль, журмын хүрээнд гүйцэтгэлийг хянаж, санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (З.Буянт), Санхүү, төрийн сангийн хэлтэс (М.Цогзолмаа), зарцуулахыг “Хан-Уул Яармаг” ОНӨААТҮГ (Б.Амартүвшин)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Ажил, үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд өмчид бүртгэж, ашиглалт, арчлалт хамгаалалтыг эзэнжүүлж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (З.Буянт), хороодын Засаг дарга нарт, холбогдох төсвийн шууд захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

1725010075


5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/13, А/298 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭН

Хан-Уул дүүргийн Засаг даргын  
2025 оны ..... сарын  
... өдрийн .....  
захирамжийн 1 дүгээр хавсралт



ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ-ын захирал

Ажлын хэсгийн гишүүд:

Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,  
төрийн сангийн хэлтсийн Хөрөнгө оруулалт хариуцсан  
мэргэжилтэн

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт,  
гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн Барилгын зураг төслийн  
төлөвлөлт, хяналт хариуцсан инженер

Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ-ын тохижилт, ногоон  
байгууламж хариуцсан инженер

Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ-ын цахилгааны инженер

Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ-ын усан хангамж, ариутгах  
татуургын инженер

Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ-ын авто замын инженер

Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч

Захиалагчийн төлөөлөл (захиалагчтай зөвшилцөж асуудал  
хариуцсан нэгж, албан хаагчийг оролцуулна.)

Нарийн бичгийн дарга :

Хан-Уул яармаг ОНӨААТҮГ-ын архив бичиг хэргийн ажилтан

Хан-Уул дүүргийн Засаг даргын  
2025 оны 9-р сарын  
2-ны өдрийн  
захирамжийн 2 дугаар хавсралт

ЗУРАГ ТӨСӨЛД ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

|                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ажлын хэсгийн дарга:   | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын<br>Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| Ажлын хэсгийн гишүүд:  | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын<br>Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн<br>Дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт<br>хариуцсан мэргэжилтэн<br><br>Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын<br>Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн хөрөнгө<br>оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан<br>мэргэжилтэн<br><br>Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын<br>Төхижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Ногоон<br>байгууламжийн гүйцэтгэл, хяналт хариуцсан<br>мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга : | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын<br>Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн<br>Барилгын зураг төслийн төлөвлөлт, хяналт хариуцсан<br>инженер                                                                                                                                                                                                                                                                                                                                               |

Хан-Уул дүүргийн Засаг даргын  
2025 оны 01 сарын  
17-ны өдрийн захирамжийн 3 дугаар хавсралт

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАРАА МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭЖ АВАХ,  
БАЙНГЫН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Хяналт–Шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэдээллийн  
технологийн мэргэжилтэн

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүүгийн тасгийн нягтлан бодогч

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Аж ахуйн тасгийн дотоод сүлжээний инженер

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн хог хаягдлын  
менежмент, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүүгийн тасгийн нярав

Нарийн бичгийн дарга :

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн тайлан  
мэдээ хариуцсан мэргэжилтэн

Хан-Уул дүүргийн Засаг даргын  
2025 оны ..... сарын  
..... өдрийн .....  
захирамжийн 4 дүгээр хавсралт

ГҮЙЦЭТГЭЛ БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын Газрын Хууль,  
эрх зүйн хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын  
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын Газрын  
Санхүүгийн тасгийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан  
бодогч